



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 30 өдөр

Дугаар A/407

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн "Жагсаалт батлах тухай" 336 дугаар тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-ын 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссоос аймгийн өвөлжилтийн нөхцөлд хийсэн үнэлгээгээр 7 суманд эрсдэлийн түвшин их, 12 суманд дунд эрсдэлтэй гарсан байх тул зудын эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр аймаг, сумын өвс тэжээлийн нөөцөд 1176 (нэг мянга нэг зуун далан зургаа) боодол ногоон өвсийг 9,408,000 (есөн сая дөрвөн зуун найман мянга) төгрөгөөр Арвайхээр сумын 5 дугаар багийн иргэн Ч.Өлзийсайхан (ийж71012219), 9800 (есөн мянга найман зуу) боодол ногоон өвсийг 39,200,000 (гучин есөн сая хоёр зуун мянга) төгрөгөөр Өв.Түвшинхангай ХХК-иас худалдан авахыг зөвшөөрсүгэй.

2. Өвс нийлүүлсэн иргэнтэй гэрээ байгуулж, өвс тэжээлийн чанар, баглаа боодол, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, хуваарилалт хийж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

3. Нийт 48,608,000 (дөчин найман сая зургаан зуун найман мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн өвсний мөнгөнөөс олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100866

D:My Doc. Zahiramj. Zasag darga